




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№02 (152) 2022 оны 03 сар

ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛИАР ШАГНАГДАВ



Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар зарлигаар төрийн дээд одон, медалиар шагнагдсан компанийн төв удирдлагын/зарим ажилтан, албан хаагчдын шагналыг компанийн удирдлага 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр гардуулан баяр хүргэж, хүндэтгэл үзүүллээ. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор төв удирдлагын ахмадын хорооны дарга Ц.Уламбаяр, ахмад настан А.Эрдэнэбилэг, Алтангадас одонгоор төв удирдлагын ахмад настан Ц.Эрдэнэ-

Очир, Ц.Жадамба болон Санхүү, эдийн засгийн хэлтсийн бараа материалын нярав Л.Төмөрсүх, Төсөл хөтөлбөрийн хэлтсийн засвар хариуцсан ахлах инженер Э.Батбаяр, Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн зураг төслийн инженер Ш.Мөнхжаргал нар тус тус шагнууллаа.

Мөн Хөдөлмөрийн хүндэт медалиар Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн горим тооцооны инженер Б.Амарбаясгалан, засварын инженер Д.Доржпүрэв, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн удирдлагын автоматжуулалт, системийн инженер Б.Баярхүү, тоолуурын инженер Ж.Хосбаяр нар энгэрээ мялаав. Эрчим хүчний яамны жуух бичгээр Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Б.Батжаргал, Захиргаа, удирдлагын хэлтсийн хамтын ажиллагаа, шагнал хариуцсан мэргэжилтэн Х.Замбага нар шагнуулж төр, түмэн олондоо хөдөлмөрөө үнэлүүллээ. Төрийн дээд одон, медалиар шагнагдсан ажилтан албан хаагчиддаа цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.



НҮҮР-3

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭНЭЭС
»ОЮУ ТОЛГОЙ» ХХК-ИЙГ
«ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ
ГЭРЭЭ»-Г ҮЗЭГЛЭЛЭЭ

НҮҮР-3

Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй
эрчим хүчний системийн тогтвортой
байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх
төслийн хамтын ажиллагааны
санамж бичигт гарын үсэг зурав

НҮҮР-3

«Эрчим хүчний сэргэлт» урьдчилсан
хэлэлцүүлэг боллоо

НҮҮР-9


«ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ ДЭД
СТАНЦЫН ЭЭЛЖИЙН МОНТЁР»-ЫН
«ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ» ОЛГОХ
СУРГАЛТ амжилттай зохион байгуулагдлаа

НҮҮР-11

КОМПАНИЙН I УЛИРЛЫН АЭД-Г
ЗОХИОН БАЙГУУЛАВ

НҮҮР-11

БИ АЗТАЙ ХҮН /ДУРСАМЖ/



ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ 10 АЖИЛ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК
Говийн бүсийн балбар

Байгуулагдсан он:

2013

Дэд станц:

5

Ажилтны тоо:

114

Суурилагдсан хүчин чадал:

700000 кВА

Хамрах хүрээ:

- Сум, суурин - 39
- Айл өрх - 21461
- Аж ахуйн нэгж - 2472

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ

220 кВ-ын шугамын трассын урт 602.1 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн урт 1113.2 км

110 кВ-ын шугамын трассын урт 89.7 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн урт 89.7 км

220/110 кВ-ын шугамын трассын нийт урт: 691,8 км

НЭГДСЭН СҮЛЖЭЭТЭЙ ЗЭРЭГЦЭЭ АЖИЛЛАЖ БАЙГАА ЭХ ҮҮСВЭРҮҮД

Ухаа худгад цахилгаан станц 18 МВТ


Цэций салхин цахилгаан станц 50 МВТ

Даланзадгад дулааны
цахилгаан станц 9 МВТ




4. 225-Р АШ-Н 3 ФАЗЫН ДАМЖУУЛАГЧ УТАС СОЛИХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.

225-р ЦДАШ-д шөнийн үзлэг хийхэд Т№708-712-н хооронд 3 фазын дамжуулагч утасны эрч суларч кронжилт үүсч байсан. Говийн бүсийн салбарын засварын 10 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2021 оны 07 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд гэмтэл устгах ажлыг зохион байгуулж 3 фазын дамжуулагч утсыг уртын дагуу шинэ дамжуулагчаар сольсон.



5. 225-Р АШ-Д ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН.

225-р ЦДАШ-н 1-р фаз нь өвөл хаврын салхины хурд ихтэй үед дамжуулагч дээр жийлт үүсч зайнд ордог байсан нь шалтгаангүй тасралт гарах нөхцөл болж байсан. Тасралтын тоог бууруулах зорилгоор 1 фазын 2ш элемент болон ПР маркийн дундын звено хасах саналыг компанийн техникийн удирдлагуудад уламжилсан. Удирдлагаас өгсөн шийдвэрийн дагуу тус салбарын засварын 11 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2021 оны 05 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд агаарын шугамын тулгуур №707-423-ийн хооронд 1-р фазын 2ш элемент болон ПР маркийн дундын звено хасах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



6. 110/35/10 КВ ДАЛАНЗАДГАД ДЭД СТАНЦАД НУМЫН ХАМГААЛАЛТ АЖИЛД ОРУУЛАВ.

110/35/10 кВ Даланзадгад дэд станцын 10 кВ-н яачейкуудын кабель оруулгын насжилт өндөр цаашид ачаалал өсөн нэмэгдэж байгаа тул нуман гэмтлийн үед шуурхай ажиллагааны ажилтнуудын аюулгүй байдал тоноглолын гэмтлийг хамгийн бага байлгах зорилгоор бие даасан нумын хамгаалалтыг дохиоллын хэлхээний хамт ажилд оруулав.



7. ХИЙМЭЛ ДАГУУЛЫН СИНХРОН ЦАГ СУУРИЛУУЛЖ ХОЛБОЛТ ХИЙН ҮНДСЭН ХАМГААЛАЛТЫГ АМЖИЛТТАЙ АЖИЛД ОРУУЛАВ.

220 кВ-н овортой 220 кВ-н Цагаансуварга-Оюутолгой ЦДАШ-г хүчдэлд залгасантай холбогдуулан 160 км урт шилэн кабелийн сувагчлал ашигласан дагуу дифференциал хамгаалалтын шилэн кабелийн чадлын өсгөгч LOOP-AM-3440 төхөөрөмжид сүлжээний тохиргоог хийж VLAN сувагчлал үүсгэж мөн хиймэл дагуулын синхрон цаг суурилуулж холболт хийн үндсэн хамгаалалтыг амжилттай ажилд оруулан 2 талаас PONOVO PW6361, T200A багажаар гүйдэл шахаж, харилцан үйлчлэлийг шалгалаа.



8. HITACHI MONITORING ТӨХӨӨРӨМЖИНД 221, 222-Р АШ-Н ГҮЙДЭЛ, ХҮЧДЭЛИЙГ ХОЛБОЖ АЖИЛЛАГААНД ОРУУЛАВ.

220/110/35 кВ Оюутолгой дэд станцын 220 кВ Цагаансуварга АШ-н нэг талын хэлхээг Япон улсын хөнгөлөлттэй нөхцөлөөр шугамын дамжууламж өндөртэй утсаар хийж тооцоо судалгааг хийхээр Hitachi мониторингийн төхөөрөмж суурилуулсан. Гэвч 220 кВ-н Оюутолгой дэд станцын өргөтгөлтэй холбогдуулан ТВЕА ХХК-ийн туслан гүйцэтгэгч болох Эрчим сүлжээ ХХК тус төхөөрөмжийн холболтуудыг салгаж орхисон. 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 220 кВ-н Цагаансуварга АШ-г залгасан тул 35 кВ-н Цагаансуваргын панелиас Hitachi-руу татсан кабелийг 221, 222-р АШ-н панельруу шилжүүлж монтажлахад бэлэн болгож Hitachi monitoring төхөөрөмжинд 221, 222-р АШ-н гүйдэл, хүчдэлийг холбож ажиллагаанд оруулав. Ингэснээр сар бүр хэмжилтийг Оюутолгой дэд станц болон Цагаансуварга дэд станцаас хуулж тооцоолол хийхэд бэлэн болголоо. Цаашид тус АШ-аар өндөр ачаалал нэвтрүүлэх үед хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулсан тооцооллыг хийж, олон улсын байгууллагаас урамшуулал төлбөр авах боломжтой юм.




9. ГЭМТЭЛТЭЙ 216 ШИРХЭГ ЭЛЕМЕНТИЙГ ШИНЭЭР ИРСЭН NP-200AH/2V/-МАРКИЙН 216 ШИРХЭГ ЭЛЕМЕНТЭЭР СОЛИВ.

220/110/35 кВ Мандал дэд станцад тогтмол гүйдлийн аккумуляторын батерей нь чанарын шаардлага хангахгүй 2 удаагийн тасралтаар дэд станцын хэвийн найдвартай ажиллагаа алдагдаад байсан тул гүйцэтгэгч компанид мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авах хүсэлтийг явуулсан. Гүйцэтгэгч компани шаардлага хангахгүй элементүүдийг бүрэн солих материал нийлүүлсэнээр аккумуляторын байгууламжийн II, I секцийн GFM-200AH/2V/-маркийн гэмтэлтэй 216 ширхэг элементийг шинээр ирсэн NP-200AH/2V/-маркийн 216 ширхэг элементээр солив. Уг ажлын үр дүнд тогтмол гүйдлийн байгууламжийн найдвартай ажиллагаа дээшилсэн.



1. 220/22/35КВ-ЫН ЦАГААНСУВАРГА ДЭД СТАНЦЫГ ХҮЧДЭЛД ЗАЛГАВ.

220/22/35 кВ Цагаансуварга дэд станцыг Вест энержи ХХК, Эрчим хүчний хөгжлийн төв, Мак ХК, ЦДҮС ТӨХК, Говийн бүсийн салбарын АШҮ-ний алба, РХАХТА гэсэн бүрэлдэхүүнтэй комисс 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд ажиллаж 220 кВ-н хүчдэлийн түвшинд шилжүүлэн ачаалал дор амжилттай залгалаа.



2. 220/110/35 КВ-Н МАНДАЛ ДЭД СТАНЦЫН 35 КВ ЗЭРЭГЦЭЭ СХЕМД ШИЛЖҮҮЛЭХ ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ ХИЙГДЛЭЭ

220/110/35 кВ-н Мандал дэд станц нь 2019 онд шинээр ашиглалтад орсон. Мандал дэд станцын хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр 35 кВ СШ-д схемийн өөрчлөлт хийж 35 кВ СШ-I,II-ыг зэрэгцээ болгох шаардлагатай болсон. Зэрэгцээ болгох ажлын ерөнхий гүйцэтгэгчээр "ГЭГЭЭН ЦАЙДАМ" ХХК ажиллаж байна. ЦДҮС ТӨХК-тай 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2021/137 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний дагуу Говийн бүсийн салбар өргөтгөлийн ажлыг 2021 оны 10 дугаар сарын 23 өдрөөс эхлэн хийж гүйцэтгэсэн.



3. 110/35/6 КВ ЦАНХИ ДЭД СТАНЦ ХҮЧДЭЛД ЗАЛГАГДАЖ ЦЭХ-НИЙ НИЙЛҮҮЛЭЛТ НЭМЭГДЛЭЭ.

Монгол улсын старатегийн чухал орд газар болох Тавантолгойн нүүрсний уурхайг тэжээх 110/35/6 кВ Цанхи дэд станцыг хүчдэлд залгахтай холбогдуулан 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад 110 кВ Цанхи-А, Б АШ-н реле хамгаалалтын тавил тохиргоог хийж, 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр амжилттай хүчдэлд залгасан.

10. КС-45717К ЗАГВАРЫН 25 ТН-НЫ МАНИПУЛЯТОРТ КАМАЗ АВТО КРАН ХҮЛЭЭН АВЛАА.

Салбарын 2021 оны хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд КС-45717К загварын 25тн-ны манипуляторт Камаз авто краныг шинээр хүлээн авч парк шинэчлэлт хийгдсэн.



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭНЭЭС “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙГ “ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ”-Г ҮЗЭГЛЭЛЭЭ

2022.01.26-ны өдөр Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс “Оюу толгой” компанийг урт хугацаанд “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-нд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болон “Оюу толгой” ХХК гарын үсэг зурлаа. Оюу толгой уурхайн хувьд цахилгаан эрчим хүч амин чухал хэрэглээ бөгөөд гүний уурхайг эхлүүлэхэд бэлэн болоод байгаа энэ цаг үетэй давхцан эрчим хүчний хангамжийн асуудлыг шийдвэрлэх нь нэн чухал үйл явдал болж байна. Ингэснээр гүний уурхай дахь ажилчдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг баталгаажуулах ач холбогдолтой бөгөөд гүний уурхайн үйл ажиллагаа урт хугацаанд тогтвортой ажиллах нь Монгол Улсын эдийн засгийн хувьд онцгой ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засгийн газраас Өмнөд говийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд болох Нарийнсухайт, Овоот толгой, Тавантолгой, Оюутолгойн зэс-алтны орд, Цагаансуварга, Шивээ-Овоо ордуудыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээг шат дараалалтайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд дээрх орд газруудыг дотоодын эрчим хүчний системээс хангах зорилгоор 670 км урттай 220 кВ (киловольт)-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, том чадлын 220 кВ-ын гурван дэд станцыг 2021 онд барьж дуусгасан. Мөн 450 МВт-ын хүчин чадалтай “Тавантолгойн дулааны цахилгаан станц”-ыг төр өөрөө бүтээн байгуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ТТДЦС ашиглалтад орсоноор Оюу толгойн уурхайн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны эрчим хүчний системээс авч буй импортын цахилгаан эрчим хүчийг орлох юм.




СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ОРОЛЦОО ИХТЭЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ

Гарын үсэг зурах ёслолын ажиллагаанд эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагдан, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Тамура Эрико нар оролцов. Монгол Улсын эрчим хүчний салбарт Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн шугамаар 1991 оноос “ДЦС-4” ТӨХК-ийн техникийн шинэчлэл, 2014 оноос тус

станцын үр ашгийг дээшлүүлэх төслүүдийг хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр амжилтай хэрэгжүүлж ирсэн. Энэхүү санамж бичгийг зурснаар Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 2030 онд 30 хувьд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Тус төслийг эрчим хүчний салбарын инженер техникийн ажилтнуудын чадавхыг дунд, урт хугацааны туршид

бэхжүүлэх, сургалт, судалгааны ажлыг 3 жилийн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний яам Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран хэрэгжүүлэх юм. Төсөл хэрэгжсэнээр Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, эрчим хүчний нэгдсэн системийн өдөр тутмын шуурхай үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохицуулах ухаалаг системийг бий болгож, сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх боломж бүрдүүлнэ.




“ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ” УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Монгол Улсын Засгийн газраас цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх, “Алсын хараа - 2050” урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан. Бодлогын хүрээнд “Монголын эдийн засгийн форум-2022” чуулга уулзалтыг 04 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгуулах юм. Чуулга уулзалтыг угтаж “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зургаан зорилт бүхий урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулагдана. Төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан “Эрчим хүчний сэргэлт” сэдвийн дор эхний урьдчилсан хэлэлцүүлэг /2022.03.21/ болж өнгөрлөө. Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг цаг алдалгүй барьж байгуулах тэр дундаа усан цахилгаан станцуудыг барих шаардлагатайг хэлэлцүүлгийн оролцогчид онцолж байв. Мөн эрчим хүчний үнэ тариф бодит өртгөөсөө доогуур тогтоогдож байгаа нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, эдгээр бүтээн байгуулалтын ажлуудыг урагшлуулахад гол саад болж

байгаа төдийгүй эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх шаардлагатай талаар оролцогчид санал хэлэв. Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт том чадлын эх үүсвэрүүд баригдаагүй нь суурилагдсан хүчин чадлын нөөц зохих түвшнээс буурч, 2021 онд эрчим хүчний системийн нийт хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, үлдсэн хэрэглээг импортоор авсан. Цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ жилд 6-7 хувиар тогтмол нэмэгдэж, шинээр хэрэглэгч холбогдох нөхцөл боломж тэр хэрээр буурч байна. Мөн дулааны цахилгаан станцуудын насжилт 35-60 жил, дамжуулах, түгээх сүлжээний насжилт 32-62 жил байгаа юм. Иймд шинэ эх үүсвэрүүдийг барьж, хүчин чадлаа нэмэгдүүлэх, санхүүгийн хувьд бие даасан, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлага тулгараад байна. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагын төлөөлүүд оролцсон. Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт, санал зөвлөмжийг нэгтгэж, үндсэн форумын үеэр мөн хэлэлцэх юм.



УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Улаанбаатар салбарын хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 358 ажилтан хамрагдсан. Өдөрлөгөөр 2022 оны төлөвлөгөөт засварын ажил эхэлж байгаатай холбоотой ажлын аюулгүй байдал хариуцагч нартай уулзалт, анхаарах зүйлсийн талаар танилцуулга хийх, ээлжит бус зааварчилгаа өгөх, тоноглолын нэршлийн стандарт шинэчлэгдэн мөрдөж эхэлсэнтэй холбоотой наряд олгогч нартай уулзалт хийх, өндөрт авирч ажиллах сургалт, ажилтнуудын цалин хөлс, компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журмын талаар танилцуулга хийх ажлыг тус тус зохион байгуулсан.



Өдөрлөгийн үйл ажиллагаа

Ажил гүйцэтгэх бригадуудад өглөө бүр урьдчилсан зааварчилгаа өгч, артерийн даралт шалган ажилд гаргаж байна.



Өдөр тутмын зааварчилгаа өгөгдөж байгаа нь

208-р АШ-ын тул№649-650-н доор кран ажиллаж байсан болон 105,106-р АШ-д тасралтын мөрөөр үзлэг хийж, тул№19-20 краны сум зайнд орсон байсан зөрчлийг тус тус арилгасан.



Хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбоотой салбарын хэмжээнд галын аюулгүй байдлын үзлэг шалгалт хийх төлөвлөгөө гаргаж, галын бүлгэмийг шинэчлэн батлуулсан. ЦДҮС ТӨХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженерийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02/339 тоот албан бичиг, “Хамгаалалтын зурвасын” дэглэм сахиулах ажлын удирдамжийн дагуу албан мэдэгдэл тараах, анхааруулах сургалт зааварчилгаа өгөх ажлууд хийгдэж, хяналт тавьж, зөрчлүүдийг тухай бүр арилган ажиллаж байна.



Айл өрх, аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл тарааж байгаа нь

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм сахиулах, хүн хоорондын зай барих, ариутгал хийх, халдварын батлагдсан болон ойрын хавьтлын мэдээ гаргах, ажлын байруудад гэнэтийн үзлэг шалгалт хийх, шаардлагатай ажилтнуудыг түргэвчилсэн шинжилгээнд хамруулах ажлуудыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллаж байна. Салбарын хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар ковид-19-өөр батлагдсан тохиолдол-192 ажилтан, ойрын хавьталд-185 ажилтан байна. Вакцины 4-р тунд нийт 144 ажилтан хамрагдсан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР


Цахилгаан дамжуулах агаарын шугам 119, 120, 131, 132, 133, 134, 205, 206, 135, 136, 137, 138, 117, 118, 208, 127, 128, 213, 214, 209, 210, 101, 102, 121, 122, 203, 204, Дундгол, Гео, Багахангайд ээлжит үзлэг, тасралтын мөрөөр 102-р АШ-ын тулгуур№1-62 хооронд, 105-р АШ-ын тулгуур№1-44 хооронд тус тус үзлэг хийсэн.



ИХБ-4-н АУРА-89-н хоёрдогч хэлхээ, программ хангамж, 110 кВ-ын Яармаг А шугам, Өмнөд дэд станцын 10, 6 кВ-ын ХТ-1, Умард дэд станцын 6 кВ-ын РП-11Б, Автосервис, Хотхон А, Р-1, РП-3А, РП-42А, РП-42Б, Хотхон-Б, Насос-8А, Насос-Б, РП-42А, РП-3Б, Р-2, ТТС-135, Гео дэд станцын Т-1-н 10 кВ-ын таслуур-1, Т-2-н таслуур-4, Т-1-н 10 кВ-ын таслуур-3, Цэвэрлэх дэд станцын 10 кВ-ын ХТ-1,2-н РХА-ийн хоёрдогч хэлхээнд болон Налайх дэд станцын Т-1-н 10 кВ-ын таслуур болон 10 кВ-ын Зах, Дулаан-1, Шилний үйлдвэр шугамуудын таслуурт урсгал засварын ажил тус тус гүйцэтгэсэн.



Гео дэд станцын төв дохиоллын хоёрдогч хэлхээ, 110/10/10 кВ-ын Гео дэд станцын Т-1-н 10 кВ-ын таслуур -1, 2, Т-2-н 10 кВ-ын таслуур -1, 2, Т-3-н 10 кВ-ын таслуур-1,2, Т-4-н 10 кВ-ын таслуур-1,2, 10 кВ-ын СХТ-1, 2, РП-28А, Б таслуур, Хөшигт дэд станцын тогтмол гүйдлийн байгууламжид тус тус их засварын ажил гүйцэтгэсэн.



110/35/10 кВ-ын Дарь-Эх, Ташгай, Арцат, 110/10 кВ-ын Улаанхуаран дэд станцуудын Т-1, 2 трансформаторын СаС-н газардуулгын холболт хийсэн.



121,122-р АШ-ын тул№128-д үерийн уснаас хамгаалах далангийн ажил хийсэн.




Цаг үеийн ажлаар:

Компанийн 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж буй Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын төвийн “Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтер”-ын сургалтад Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 5 ээлжийн монтерыг 2022 оны 03 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд амжилттай хамрууллаа.



110/35/10 кВ-ын Зайсан дэд станцын ДХТ-1-н 10 кВ-ын кабелийн үзүүр муфт гэмтсэнг шинээр муфт хийн, ячейканы үүрэнд үйлчилгээ хийж, тэг дараалын гүйдлийн трансформаторыг сольж хэвийн болгосон.






ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ


Салбарын нийт 175 ажилтанд ажлын байрны сургалт явуулж ээлжит шалгалтыг үе шаттай авч бүрэн дуусгалаа. Энэхүү шалгалтыг ажлын байран дээр чадамжаар авсан нь онцлог байлаа.



Дэд станц, шугамын засварын монёрууд, реле хамгаалалт, хэмжүүр, туршилтын монтер инженерүүдийн ажлын байрны онцлогт тохирсон чадамжийн төлөвлөгөө боловсруулж батлуулан ажлын байранд ээлжит шалгалтыг авсан. Энэ нь шалгалтаас гадна томоохон сургалт, дадлага болж ажилтануудад өгөөжтэй шалгалт боллоо.



Засварын бэлтгэл ажлыг хангах, ажлыг аюул, эрсдэлгүй явуулах зорилгоор урсгал болон их засварын ажил гүйцэтгэх 100 ажлын эрсдлийн үнэлгээ боловсруулсаныг хянаж баталгаажуулан бригадуудад өгсөн. Энэхүү эрсдлийн үнэлгээнд хийх ажлын агуулга, ажлын зааг хязгаар, ажлыг аюулгүй гүйцэтгэх технологи ажиллагаа зааварчилгааг тусгаж өгсөн.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Герман улсын KFW банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Төвийн бүсийн салбарын Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн шинэчлэл хийх, ажлын эзэлхүүнийг хэлэлцэхээр төслийн багийнхан ирж ажиллалаа. Салбарын ерөнхий инженерийн бүрэлдэхүүнтэй комисс болон KFW төслийн багийн хүмүүсийн хамт Борнуур, Зүүнхараа, Баруунхараа, Шарын гол, Дархан, Тосгон, Үйлдвэр, Хөтөл, Орхон дэд станцуудаар явж хийгдэх ажлын эзэлхүүнийг газар дээр нь танилцуулах ажил хийгдсэн байна. Төслийн хүрээнд: 13 дэд станцын 110 кВ-ын таслуур, 6 дэд станцын 35 кВ-ын таслуур, Дархан дэд станцын РХА-ын тоноглол, хяналт удирдлагын систем шинэчлэх, Транзит агаарын шугамуудын аянгийн троссыг шилэн кабелийн аянгийн троссоор солих ажлын төсөв ирүүлсэн үнийн саналын дагуу хийгдсэн байна.




Салбарын хэмжээнд хэт улаан туяаны хэмжилтийн /VariaCom/ багажаар 18 дэд станцуудын бүх тоноглолуудын холболтуудад халалт хэмжих, ОПУ, ЗРУ-н байруудад дулаан алдалт хэмжих ажил зохион байгуулсан байна.



Хэмжилтээр тоноглолуудын их бие, шин, дамжуулагч утасны холболтууд, 6 кВ-н кабелийн холболтууд мөн 0,4 кВ-н тоноглолуудын автоматуд, халаагуур гэрэлтүүлгийн кабель гэх мэт цэгүүдэд халалт хэмжсэн ба хэмжилтээр Бурхант дэд станцын Т-1 трансформаторын 6 кВ-н оруулганы А фаз, Т-2 трансформаторын 6 кВ-н оруулганы В фазын холболтын зажим цуурч халалттай байсанг илрүүлсэн.

Засварын бригад бүх фазуудын холболтын зажимуудыг солих арга хэмжээ авч Т-2-г залгасны дараа холболтууд дээр халалт хэмжих ажлыг гүйцэтгэхэд хэвийн байсан.



Нийт 33 нэр төрлийн халалт зөрчил илрүүлсэн ба цаашид бүх станцуудын хэмжилтийн үр дүнг харгалзан халалттай гарсан тоноглолуудын холболтуудад чангалгаа үйлчилгээ хийлгэх талаар энэ оны засварын төлөвлөгөөнд оруулан устгуулах арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна. Салбарын Техникийн зөвлөлийн I улирлын хурлыг цахимаар 2-р сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу Төвийн бүсийн салбарт хийгдэх дараах нэр бүхий ажлуудыг ярилцсан байна.

1. Дулаанхаан дэд станцын 110 кВ-н портал босгох ажлын зураг батлуулах - Компанийн ҮТЗ-н I улирлын хурлаар хэлэлцүүлэх;
2. Үйлдвэр дэд станцын РХА-н шинэчлэлийн ажлын 2 дугч хэлхээний схем батлуулах
3. Баясгалант, Орхон дэд станцуудад 110 кВ-н ХТ-г суурилуулах ажил,

Нэмэлтээр:

1. 110 кВ-н Ерөө АШ-д тулгамдаж буй асуудал
2. KFW төсөлд хэрэгжүүлэх ажлын танилцуулга тус тус хэлэлцэн шийдвэр гаргасан байна.



Агаарын шугамын ээлжит болон ээлжит бус үзлэг:

1. 110 кВ-ын 113, Үйлдвэр А.Б, Дархан-Сүхбаатар, Сүхбаатар-ДХ, Хөтөл А.Б,

Орхон, Ерөө-Бугант, 220 кВ-ын 201, 202, 257, 258-р агаарын шугамуудад нийт уртын дагуу ээлжит үзлэг хийв. Үзлэгээр СБ, 257, 258-р агаарын шугамын чичэргээ намжаагч гүйсэн, өндөр мод ургасан, шувууны үүртэй, ригель ил гарсан, элемент хагархай зэрэг гэмтэл зөрчлүүд илэрсэн.

2. 110 кВ-ын Ерөө агаарын шугамын Т№215-248, Т№73-155 хүртэл өндөрийн үзлэгийг хийж, үзлэгээр Т№ 68-н В фаз, Т№71-н В фаз, Т№148-н А фазад жийл тасарсан, АТ№73, Т№72, 83, 89, 75, 148, 155, 215, 221, 238, 239, 245, 248-н дээд доод элемент нэвт цохигдсон гэмтэл зөрчлүүд илэрсэн.
3. Тасралтын зоонд ээлжит бус үзлэгийг 110 кВ-ын Ерөө агаарын шугамын Т№ 50-150, 140-240 хооронд, 220 кВ-ын 208-р агаарын шугамын нийт уртад тулгуурын төмөр хийц хэсгүүдэд хийсэн. Үзлэгээр илэрсэн алдагдсан угольник боолт сэргээх ажлыг хийж хэвийн болгосон.



Б. Төлөвлөгөөт бус гэмтэл устгалтын ажил

1.110 кВ-ын Ерөө агаарын шугамын тасралтын мөрөөр үзлэг хийж нийт 25-н тулгуурт 28-н гэмтэл илэрч 1, 2, 3-р бригадууд 19-н тулгуурын 19-н фазад 48 ширхэг нэвт цохигдсон элемент сольж, 4 тулгуурт 5 цэгт РАС-70 шахаж утас завсарлах, Т№186, 187-н утас баригч дээр гайх суларсанг конторлох, 110кВ-ын Хөтөл А.Б-АШ-ын үзлэгээр илэрсэн хагархай элемент солих, чичэргээ намжаагч гүйсэн, утасны гэмтэл засварлах ажлуудыг гүйцэтгэсэн.



Цаг үеийн ажлын талаар: Цасны баяр

Салбарын ажилтнуудыг цэвэр агаарт биеийн болон оюуны алжаал тайлах, ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл агаар, идэвхитэй амралт, хамт олны эв нэгдэл, нөхөрсөг харьцааг бэхжүүлэх зорилготой цасны баярыг инженерийн хэсгийн хамт олон зохион байгуулж тус арга хэмжээнд салбарын 80 ажилтан хамрагдсан.




Төвийн бүсийн салбарын цасны баярын үйл ажиллагаа ДУА-ын ААН, байгууллагуудын дунд зарласан уралдаанд 2-р байр эзэлж шагнуулсан.

Ажилтныг сургаж, дадлагажуулах, мэргэшүүлэх багш-шавийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Ахмад туршлагатай ажилтны дадлага, мэргэжлийн туршлагыг шинэ залуу ажилтнуудад өвлүүлэн үлдээх, залуу ажилтнуудыг дэмжих, сургах, дадлагажуулах, зарим ажил мэргэжлийн нөөц ажилтныг бэлтгэж сургахад чиглэсэн багш-шавийн гэрээг байгуулан ажиллаж байна.

1. ЗААА-ны 25тн краны оператор-жолооч Ж.Энхболд /багш/, тусгай зориулалтын автомашины жолооч Х.Ганбаатар/ шавь/,
2. Сагст өргөгч машины оператор-жолооч Д.Ганбаатар/багш/ - суудлын автомашины жолооч Ц.Мөнхжаргал/ шавь/ нар нь энэ онд багш шавийн гэрээтэй ажиллаж байна.





ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 01, 02-р саруудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Ээлжит шалгалтын талаар: Салбарын нийт ажилтнуудын 2022 оны ААД, ТАД-ийн мэдлэгийн ээлжит шалгалтыг 02 сарын 09-ны өдрөөс 02 сарын 21-ны өдрүүдэд дүрэм, зааврууд, холбогдох хууль тогтоомжууд болон ээлжит сургалтын материалуудаас бэлтгэсэн асуултыг My test программ ашиглан тэстээр авлаа. Ээлжит шалгалтанд салбарын нийт 146 ажилтан хамрагдаж 93.8%-ийн амжилттайгаар шалгагдлаа.



Наряд, шийдвэрээр хийсэн ажлын талаар:

Салбарын харъяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 31, шийдвэрээр 112 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 393 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан.

Дасгал, зааварчилгааны талаар:

Салбарт шинээр ажилд орсон 1 ажилтанд урьдчилсан зааварчилгааг, 3 ажилтанд

ажлын байрны анхан шатны зааварчилгааг, 2681 ажилтанд өдөр тутмын зааварчилгааг, 267 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгааг, ээлжит бус зааварчилгааг 250 ажилтанд тус тус өгч ажилласан байна. Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваари эсэргүүцэх дасгал 11 удаа хийгдэж нийт 112 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 4 удаа хийгдэж, нийт 60 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 3 удаа хийгдэж, нийт 42 ажилтан, тус тус хамрагдсан байна.

ХАБЭА-н бүх шатны үзлэгийн талаар:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 89 удаа хийж 173 зөрчил, II шатны үзлэгийг 18 удаа хийж 54 нэрийн зөрчлийг илрүүлэн устгах арга хэмжээг авч ажиллалаа.





ХАБЭА-н III шатны үзлэгийг салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр ахлагчтай комисс салбарын харъяа 10 дэд станцад 02 сарын 15-ноос 02 сарын 21-ний өдрүүдэд хийж, нийт 52 нэрийн зөрчлийг илрүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 35 удаа хийж 14 нэрийн зөрчлийг илрүүлэн устгалаа. Салбарын харъяа ажлын байруудад ашиглагдаж байгаа нийт гал унтраагууруудын хяналтын картыг шинэчлэн, үзлэг шалгалтын тэмдэглэгээг сар бүр хийн ажиллаж байна.

Сургалтын талаар:



2022 оны 01-р сарын 12-ноос 14-ний хооронд салбарын ажилтнуудын нэгдсэн сургалтыг цахимаар явууллаа.

Сургалтын хөтөлбөрт:

1. Трансформаторын тухай засвар үйлчилгээ ашиглалтын үед анхаарах зүйл
2. ЦДАШ-ын хамгаалалт
3. Дэд станцын оператив тэжээлийн тухай
4. Микропроцессийн реле хамгаалалтын давуу тал, онцлог, ажиллах зарчим
5. Трансформаторын хамгаалалт, Шинийн хамгаалалт
6. Аваарийн тасралтуудын талаар дүн шинжилгээ
7. Ажлын байрны соёл 5С
8. Шуурхай ажиллагааны заавар, ТЗЭ байгууллагуудтай харьцах харьцааны заавар
9. ХАБЭА-н стандарт
10. Вакуум, элегаз, тосон таслуурын засвар тохируулга, таслууруудын удирдлага, приводны бүтэц, ажиллах зарчим
11. Хэмжүүрийн багаж /амперклевш, мегометрийн багажны бүтэц, багажны ажиллагаа
12. Тостой тоноглолоос сорьц авах аргачлал
13. Хүн ба хөгжил
14. Хөдөлмөрийн тухай
15. Эрчим хүчний салбарт нэвтрүүлж буй шинэ техник технологи



2022 оны 02-р сарын 28-наас 03-р сарын 01-ний хооронд Өргөх зөөх, машин механизм, оосорлогч дохиочны эрх олгох болон эрх сунгах сургалтад нийт 27 /танхимаар-13 цахимаар-14/ ажилтан хамрагдаж шалгалтыг 2022 оны 03-р сарын 01-нд 100% хамрагдсан.



2022.03.07-нд Салбарын нийт ажилтнуудад "Дархлааний систем" сэдвээр эм зүйч Д.Азаяа сургалт явууллаа.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

03 дугаар сарын 03-ны өдөр Эрдэнэт дэд станцын Т-1, Т-2 трансформаторын УДГХ-ыг таслах хэлхээнээс дохиоллын хэлхээнд шилжүүлэв.

03 дугаар сарын 09-ний өдөр Сансар дэд станцын Т-1 трансформаторын РПН-ийн байрлалыг VII-оос V байрлалд шилжүүлэв.

03 дугаар сарын 10-ны өдөр Цэцэрлэг, Баянтээг, Мөрөн, 11-ний өдөр Булган, 14-ний өдөр Эрдэнэт дэд станцын ИХБ болон ХХБ-уудад цэвэрлэгээ хийв.

03 дугаар сарын 11-ний өдөр Эрдэнэт дэд станцад 203, 204 дүгээр шугамын РХА-ийн байгууламжид үзлэг хийж, үндсэн хамгаалалтын ажиллагааг шалгав.

03 дугаар сарын 11-ний өдөр Мөрөн дэд станцын ИХБ-ууд дахь галын элсийг солив.

03 дугаар сарын 11-ний өдөр Цэцэрлэг дэд станцын Т-1, Т-2, Баянхонгор дэд станцын Т-3 трансформаторуудын РПН-ийн байрлалыг Х-аас IX байрлалд шилжүүлж, Мөрөн дэд станцад 35кВ-ын СХТ-ыг залгав. 03 дугаар сарын 14-ний өдөр Хархорин дэд станцын Р-3 реакторын кабель болон тоноглолын нэр хаягийг сэргээв.

Их засвараар хийгдсэн ажлууд:

01 дүгээр сарын 12-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Мөрөн дэд станцын ОПУ-ын барилгын засварын ажил хийгдэв.



03 дугаар сарын 02-ны өдрөөс 04-ний өдрүүдэд Эрдэнэт дэд станцад 6кВ-ын СХТ-ын РХА-н засварын ажил хийгдсэн.

• 03 дугаар сарын 10-ны өдрөөс 11-ний өдрүүдэд Хархорин дэд станцад 10кВ-ын Р-2 реакторын РХА-ын засварын ажил хийгдэв



Урсгал засвараар хийгдсэн ажлууд:

• 03 дугаар сарын 10-ны өдөр Арвайхээр дэд станцад УКП-1, УКП-2

03 дугаар сарын 10-ны өдөр Эрдэнэт дэд станцад 220кВ-ын ХТ-2 трансформаторын РХА, 03 дугаар сарын 11-ний өдөр Арвайхээр дэд станцад төв дохиоллын засварын ажлууд хийгдэв.

Гэмтэл устгалтаар хийгдсэн ажлууд:

01 дүгээр сарын 04-ний өдөр 110кВ-ын Хялганат-А шугамын №32, 43, 05-ний өдөр 110кВ-ын Хялганат-Б шугамын №75 дугаар тулгуурын А фазад нэвт цохигдсон элементийг гирляндаар нь солих ажлыг ЗА-ны засварын мастер Ч.Анхдаваагийн бригад хийж гүйцэтгэн 01 дүгээр сарын 21-ний өдөр 201, 202 дугаар шугамын №253 тулгуурт 1 ширхэг L, №279 тулгуурт 2 ширхэг L, №280-281 тулгуурт 1 ширхэг доод тушаа төмөр гүйцээх ажлыг ЗА-ны засварын мастер Ч.Анхдаваагийн бригад хийж гүйцэтгэсэн.





02 дугаар сарын 11-ний өдөр 110кВ-ын Хархорин-Цэцэрлэгийн шугамын №319-320 дугаар тулгуурын I фазын утсанд 3-4 судал тасарсан цэгт РАС тавьж, №328-329 дугаар тулгуурын III фазын утсанд СОАС-ын угаар 4-5 судал тасарсан цэгт ороолт хийх ажлыг засварын мастер Б.Чагнаадоржийн бригад хийж 02 дугаар сарын 19-ний өдөр 110кВ-ын Хархорин-Арвайхээрийн шугамын №287-288 дугаар тулгуурын II фазын утсанд 1 судал тасарч унжсан цэгт ороолт хийх ажлыг АШУ-ний инженер Б.Хонгорзулын бригад хийж гүйцэтгэсэн. Энэ үед Хархорин дэд станцад Арвайхээр 110кВ-ын ШУС-ын В,С фазад тохиргоо, чангалгаа, Баянхонгор дэд станцын Т-1 трансформаторын 110кВ-ын С фазын оруулга, 6кВ-ын кабельд чангалгаа, үйлчилгээ хийв.





02 дугаар сарын 26-ны өдөр 110кВ-ын Хархорин-Цэцэрлэгийн шугамын №116 дугаар тулгуурын III фазын утсанд ЧН-ийн угаар 7-9 судал тасарсан цэгт РАС тавьж, №116-117 дугаар тулгуурын III фазын утсанд ЧН-ийн угаар 7-9№976 дугаар тулгуурын III фазын утсанд 5-7, №117 дугаар тулгуурын III фазын утсанд ЧН-ийн угаар 7-9 судал тасарсан цэгт 50-90 метр оруулга, №976, 188

дугаар тулгуурын I, №116 дугаар тулгуурын III фазын утсанд 3-4 судал тасарсан цэгт ороолт хийх ажлыг засварын мастер Б.Чагнаадоржийн бригад хийж гүйцэтгэсэн.



03 дугаар сарын 10-ны өдөр 203, 204 дүгээр шугамын №359, 372, 398 дугаар тулгууруудад дээд, №374, 427 тулгууруудад доод талд рого тавьж, 17 тулгуураас шувууны үүр авч, боолт гайка гүйцээв. 03 дугаар сарын 11-ний өдөр 203 дугаар шугамын №293, 294, 326, 327, 204 дүгээр шугамын №291, 292 дугаар тулгууруудад ЧН тавив.



ТЗБАХ-аар хийгдсэн ажлууд:

01 дүгээр сарын 20-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Мөрөн дэд станцад Т-1, Т-2 трансформаторуудад саармагийн салгуур, цэнэг шавхагч суурилуулах ажлыг хийж гүйцэтгэв.

03 дугаар сарын 03-ны өдрөөс 04-ний өдрүүдэд Хархорин-Арвайхээрийн ӨҮХ, 03 дугаар сарын 06-наас 14-ний өдрүүдэд Эрдэнэт-Хялганатын ӨҮХ шинэчлэх ажил хийгдэв.

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бүх төрлийн дасгалын явц, түүний чанар, зааварчилгааны мөрдөлтөд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2022 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 8 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 546 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 630 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 661 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаад байна.

2022 оны мэдлэгийн ээлжит шалгалт, давтан шалгалт авах ажлыг 2022 оны 02 дугаар сарын 13-наас 03 дугаар сарын 04-ний хооронд "My test" программыг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд салбарын харьяа алба, хэсэг, дэд станцуудийн нийт 189 ажилтан хамрагдаж, 100%-ийн амжилттай шалгагдсан байна.

2022 оны 1-р улирлын ХАБЗА, ашиглалт засварын III шатны үзлэгийг 2022 оны 02 сарын 13-наас 2022 оны 03 сарын 06-ны өдрүүдэд салбарын хэмжээнд зохион байгуулж нийт 115 зөрчил илрүүлж хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. 2021 оны 3-р улирлын III шатны үзлэгийн гүйцэтгэл 92.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2022 оны "Хамгаалалтын зурвас" -ын дэглэм сахиулах аяны хүрээнд компанийн Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваагийн 2022 оны 03 сарын 09-ний өдөр ирүүлсэн удирдамжийн дагуу салбарын хэмжээнд хийгдэх 10 ажилбар бүхий төлөвлөгөөг гаргаж батлуулан 2022 оны 03 сарын 14-ний өдрөөс 05 сарын 16-ны хооронд зохион байгуулахаар ажиллаж байна.

ДҮТ ТӨХХК-ийн техник хяналт судалгаа хөгжил хариуцсан дэд захирал Б.Эрхэмзаяагийн 2022.03.07-ны өдрийн 04/304 тоот төлөвлөгөөт шалгалт хийх тухай албан бичгийн дагуу 40 нэр төрлийн, 298 заалт бүхий хяналтын хуудсаар 2022.03.14, 15-ны өдрүүдэд хяналт шалгалтад хамрагдсан.



"Коронавируст" халдварын талаарх мэдээлэл:

Вакцинжуулалтын нэмэлт 3-р тунд 2022 оны 03 сарын 21-ний байдлаар 175 ажилтан буюу хамрагдвал зохих нийт ажилтны 84,9 хувь нь хамрагдсан, вакцинжуулалтын 4-р тунд одоогоор 11 ажилтан хамрагдаад байна. 2022 он гарсаар коронавирусын халдвар авч батлагдсан нийт 20 тохиолдол байна. Эдгээр 20 ажилтан бүрэн эдгэрч ажилдаа орсон байна. Сүүлийн нэг сарын хугацаанд шинээр халдвар авч батлагдсан тохиолдол байхгүй. Мөн батлагдсан тохиолдлын ойрын хавьталаар тусгаарлагдсан ажилтан байхгүй байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг салбарын хэмжээнд 12 дэд станцын барилга байгууламж, албан контторууд, авто гражууд, машин механизмуудыг бүрэн хамруулж 7 хоног бүр нийт 18000 гаруй метр квадрат талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, гэнэтийн болзошгүй аваар, саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугам тоноглолд үзлэг хийх график гарган удирдлагаар батлуулж графикайн дагуу инженер техникийн ажилтнаар ахлуулсан бригад үзлэгийг 2022 оны 01 дүгээр сарын 15-наас 25-ны өдрийн хооронд салбарын харьяа 220/110 кВ ЦДАШ-уудад ээлжит үзлэгийг зохион байгуулж хийлээ. Үзлэгийг Чойр хэсгийн засварын мастер Н.Наранбаяр, Инженерийн хэсгийн засварын инженер Г.Алтангэрэл Сайншанд хэсгийн ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Л.Бямбадорж Өндөрхаан хэсгийн ашиглалт шуурхай үйлчилгээний инженер П.Түвшинтөр нар хийж гүйцэтгэв.

Нийт 19 ЦДАШ-нд үзлэг хийснээс 123 ширхэг гэмтэл илэрсэн байна дээрх гэмтэл нь агаарын шугамын тасралтад шууд нөлөөлөхөөр гэмтэл байхгүй тул 2022 оны урсгал засварын ажлаар устгахаар төлөвлөөд байна. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан 110/6 кВ Хот, Төв дэд станцын 6 кВ ХХБ-н гэрэлтүүлэг сайжруулах ажил, машин механизмд техникийн үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. **Засварын ажлаар:** 2022 оны 03 сарын 21-ний байдлаар 220/110/35/6 кВ Чойр дэд станцад 6 кВ ХХБ-н халаагуурын цахилгаан хэлхээний их засварын ажлыг 3,3 сая төгрөгөөр, Ашиглалтын түвшин үзлэг үйлчилгээний 37 ажлыг 1,3 сая төгрөгөөр, Гэмтэл устгалын 13 ажлыг 0,3 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгээд байна.

Гэрээт ажлын хүрээнд: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон Монцемент Билдинг Материалс ХХК-ийн хооронд байгуулсан ашиглалт засварын гэрээний дагуу РХХТ-ын хэлтсийн хэмжилт туршилтын бригад, ЗӨБ-н салбарын РХАХТ-ын албаны бригад, Сайншанд хэсгийн засварын бригад, 110/35/10 кВ Сайншанд дэд станц, 110/6 кВ Булагт дэд станц болон Өргөн ДЦС-ын тоноглолд ээлжит хэмжилт, туршилт, РХА шалгах, 110 кВ Булагт ЦДАШ-нд дээд үзлэг хийж гэмтэл устгах ажлуудыг 2022 оны 03 дугаар сарын 01-06-ны өдрүүдийн хооронд зохион байгуулж холбогдох тайлан гаргаж ажилласан.



Сургалт, бүтээмжийн чиглэлээр зохион байгуулагдсан ажлууд:

- Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтёрын "Чадамжийн гэрчилгээ" олгох сургалт Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр 2022.03.09-ний өдрөөс 2022.03.18-ны өдрийг дуустал хугацаанд хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулагдсан. Тус сургалтад 5 салбарын нийт 21 ажилтан хамрагдсан. /УБС-5, ХБС-5, ТБС-3, ЗӨБС-5, ГБС-3/



- 2022 оны 03-р сарын 18-ны өдөр Зүүн-Өмнөд бүсийн салбарт "Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үнэлгээ гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах арга зүйч Б.Отгонбүжмаа, арга зүйч Э.Ундрал болон Эрчим хүчний хөгжлийн төвөөс хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын цахилгааны мэргэжлийн инженер С.Жигжиджав, цахилгааны мэргэжлийн инженер Х.Эрдэмбилэг, ЦДҮС ТӨХК-ийн ЗУХ-ын сургалт, бүтээмжийн инженер Л.Энхжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллав. Хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын баг онол болон дадлага гэсэн 2 чиглэлээр 21 ажилтнаас шалгалтыг авсан. Нийт ажилтнууд хангалттай үнэлгээ авсан.



Олон нийтийн чиглэлээр:


2022 оны 03-р сарын 11-ний өдөр Чойр хэсгийн дарга Алтангадас одонт Монгол улсын зөвлөх инженер Баасанжавын Туяагийн хөдөлмөрийн алдарыг тэмдэглэж ЦДҮС ТӨХК-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын хамт олон хүндэтгэл үзүүллээ. Б.Туяа нь Чойр хэсэгт хамгийн олон жил ажиллаж, энэ хугацаандаа шинэ санал санаачлага олныг гарган, олон тоноглолын шинэчлэлтэд гар бие оролцон, олон залуусыг сургаж бэлдсэн юм.

Ингээд Б.Туяа инженерийнхээ цаашдын ажил амьдралд нь амжилт, аз жаргалаар дүүрэн бялхаж явахын өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье.



Чойр хэсгийн засварын монтёр Ө.Отгонбатын гэр шатаж гэр бүлд нь гарз хохирол учирсан. Иймд Ө.Отгонбатад компанийн зүгээс мөнгөн тэтгэмж олгон, салбарын хамт олон мөнгөн болон эд материалын тусламж үзүүлээ.





ГОВИЙН БҮСИЙН САЛБАР


ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2022 оны 01, 02 дугаар саруудад нарыдаар 4, шийдвэрээр 54 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 11 удаагийн дасгал зохион байгуулагдаж 122 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 166 хүн, тухайлсан зааварчилгааг 399, ээлжит бус зааварчилгааг 423 хүнд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 509 удаа хийж 37 зөрчил, II шатны үзлэгийг 19 удаа хийж 27 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 62 удаа хийж ажилласан.

2022 оны мэдлэгийн ээлжит шалгалтыг 02 дугаар сарын 09-ний өдрөөс 03 дугаар сарын 04-ний өдрийн хооронд авч, нийт 94 ажилтан шалгалт өгснөөс эхний удаагийн шалгалтанд 40 ажилтан, давтан өгсөн шалгалтанд 11 ажилтан хангалтгүй үнэлгээ үзүүлж 3 дахь удаагийн шалгалтад 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд хамрагдана.



Сар шинийн баярын амралтын өдрүүдээр шугам тоноглолын найдвартай ажиллагааг



ханган ажиллах тухай Говийн бүсийн салбарын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/02 дугаар тушаалын дагуу 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 20:00 цагаас 2022 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 08:00 цаг хүртэл хариуцлагатай жижүүрүүд ажиллав. Хариуцлагатай жижүүрээр инженер техникийн 4 ажилтан, суудлын автомашины 4 жолооч батлагдсан хуваарийн дагуу дэд станцуудын горим схемийн байдалтай танилцан хариуцлагатай жижүүрийн журнал хөтөлж, компанийн хариуцлагатай жижүүрт салбарын үйл ажиллагааны мэдээ өгч ажилласан.

2022 оны I улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийг 02 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 04-ний өдрийн хооронд компанийн хэмжээнд ашиглагддаг ХАБЭА-н үзлэгийн хуудсаар дүрэм журмын хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажил, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, техникийн бичиг баримт бүрдүүлэлт, хөтлөлт, өндрийн ажлын аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, дотоод хяналт /нарядын системийн мөрдөлт, СЗ-н хуудсын ашиглалт, ША-ны схем/ зэргийг шалгаж, дэд станцын анхдагч хэлхээний тоноглолуудад нарийвчилсан үзлэгийг хийж, ажилтнуудын санал хүсэлтийг авч ажилласан.

Үзлэгээр үнэлэгдсэн ололттой, дэвшилтэд санал санаачилга:

Тавантолгой дэд станцын ээлжийн инженер Т.Бадарчингийн санаачилгаар ажилтнууд дотооддоо зохион байгуулсан сургалт, дасгал, давтан зааварчилгааны талаар тэмдэглэл хөтлөх дэвтэр нээн баяжилт хийсэн байна. Уг дэвтэрт ажилтнууд

ойлгосон зүйлсээ бичиж, дэд станцын АШУ-ний инженерээр тухай бүрт нь дүгнүүлж хэвшүүлсэн байна. Энэ шийдэл нь ажлын байр бүрт нэвтрүүлж болох санал санаачилга гэж дүгнэсэн.




Даланзадгад дэд станцын АШУ-ний инженер Т.Жавхланзориг нь ХАБЭА-н II шатны үзлэг хийхдээ өөрийн боловсруулсан галын хорны үзлэгийн хуудсыг ашиглан галын багаж хэрэгсэл болон хоронд үзлэг хийж баталгаажуулсан байна. Энэхүү хуудсаар бусад алба хэсгүүдэд ажлын байр бүрт нэвтрүүлж болох санал санаачилга гэж дүгнэсэн.

Сургалт дадлагууламжын чиглэлээр:

Нийт ажилтнуудын ээлжит сургалтыг Говийн бүсийн салбарын даргын 2022 оны 01 сарын 14-ний өдрийн А/01 дугаар тушаалаар 01 сарын 17-ны өдрөөс 01 сарын 19-ний өдрүүдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу танхим болон цахимаар /zoom/ зохион байгуулсан. Танхимаар сургалтад оролцсон ажилтнууд компанийн ГХШ-аас өгсөн шийдвэр, зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан сургалтанд оролцсон.

Сургалтыг Монгол улсын зөвлөх инженер Ж.Ханд-Иш, ХМХ-ийн ХАБЭА-н инженер Б.Батчулуун, Дундговь аймгийн архивын тасгийн дарга Т.Уранбайгаль, МХГ-ын эрчим хүчний хяналтын улсын байцаагч Б.Золжаргал, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч И.Тогооч, ОБГ-ын сургалт хариуцсан мэргэжилтэн Н.Цэрэнням, Гэрэлтдэг ертөнц ТББ-ын сургагч багш М.Санжаасүрэн, Монголын хүний нөөцийн институтын сургагч багш Д.Бартанбаатар болон салбарын инженер техникийн 8 ажилтан 20 сэдвийн хүрээнд 26 цагийн хичээлийг зааж давхардсан тоогоор 105 ажилтан хамрагдсан байна.

Ээлжит сургалтын ирцийн бүртгэлийг тогтмол хийж ажилтнуудын оролцоонд хяналт тавьж ажилласан.



Салбарын 2022 оны сургалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу бичиг хэрэг, архивын ажилтан Б.Мөнхцэцэг Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй 1 сарын хугацаатай "Архив албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалт"-д цахимаар хамрагдаж байна. Мөн Зүүн өмнөд бүсийн салбарт зохион байгуулагдаж буй "Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтер"-ын "Чадамжийн гэрчилгээ" олгох сургалтад 3 ажилтан хамрагдаж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

110/35/10 кВ-н Мандалговь дэд станцад 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 35 кВ-н Олгойнговь АШ-н гаргалгааны таслуур болон шугамын салгуурыг холбосон хөнгөн цагаан шин тасарч хальсан гэмтэл гарсан. Тус гэмтэлийн мөрөөр засварын бригад аваарын дуудлагаар ажиллан шинд залгаа хийж гэмтэлийг устгах арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулж хэвийн болгосон.



110 кВ-н Даланзадгад АШ-н тулуур №313-ын овоолго суусан гэмтэл илэрсэнийг засварын бригад 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр гэмтэл устгах ажлыг зохион байгуулж хэвийн болгосон.



РХАХТА-ны дарга Т.Цэнгэлээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 06-ны өдрийг дуустал 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцын 35 кВ-н Төмөр зам-1, 2 АШ-н реле хамгаалалтын тавилыг албан бичгийн дагуу тохируулж, реле хамгаалалтын панельд PONOVO PW636i багажаар гүйдэл шахаж хамгаалалтын ажиллагааг шалгав. Мөн гүйдлийн трансформаторын анхдагчаар фаз бүрт гүйдэл шахаж гүйдлийн хэлхээг шалгахад хэвийн байна



Цаг үеийн ажлаар:

Дундговь аймгийн Улаан загалмайн нийгэмлэг болон нэгдсэн эмнэлгийн цусны төвөөс 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан. "Цусны донорын тухай" сургалтад ажилтнууд хамрагдаж сайн дурын донор элсүүлэх аянд нэгдсэн.



Салбарын нийт ажилтнуудын нийтийн мэдээллийн цагийг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр, 03 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус мэдээллийн цагаар салбарын удирдлагууд цаг үеийн асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, ажилтнуудын цалин нэмэгдэл, шинээр гарсан тушаал шийдвэрүүд, сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар, түүний мөрөөр хийх ажлын төлөвлөгөө зэрэг мэдээлэл хийсэн. Цаашид нийт ажилтнуудын нийтийн мэдээллийн цагийг 14 хоног тутамд тогтмол хийхээр төлөвлөж байна.



Улс орон даяар халдвар хамгааллын дэглэм буурч ажлын цагийн хэвийн горимд шилжин ажиллаж байна. Тус салбарын ажилтнуудын хувийн сахилга бат, цаг ашиглалт, ажлын байрны эмх цэгцгийг сайжруулан зөв дадал хэвшүүлж, нэг зорилготой нэгдмэл хамт олон болгох зорилгоор "Зөв дадал-Зорилготой амьдрал" сэдэвт сарын аяныг 03 дугаар сард зохион байгуулан ажиллаж байна.

ТӨВ УДИРДЛАГА

“ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ ДЭД СТАНЦЫН ЭЭЛЖИЙН МОНТЁР”-ЫН “ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ” ОЛГОХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА


Компанийн 2022 оны Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн №А/109 тоот тушаалаар “Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтер”-ын “Чадамжийн гэрчилгээ” олгох сургалтыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр 2022 оны 03-р сарын 09-ний өдрөөс эхлэн 03-р сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдлаа. “Хуваарилах байгууламж дэд станцын ээлжийн монтер”-ын сургалт батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу нийт 80 цагийн танхимийн болон дадлага ажил хэлбэрээр зохион байгуулагдсан. Сургалтад нийт 21 ажилтан хамрагдсан.

Сургалтын төгсөлтийн шалгалтыг 2022 оны 03-р сарын 18-ны өдөр зохион байгуулсан ба тус шалгалтад ХНХЯ-ны харъяа “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв”-ийн болон Эрчим хүчний хөгжлийн төвийн хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын 4 хүний бүрэлдэхүүнтэй баг, ЦДҮС ТӨХК-ийн ЗУХ-ын сургалт, бүтээмжийн инженер Л.Энхжаргал нар ажиллалаа. Тус сургалтад хамрагдсан суралцагчид хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын багт онол болон ур чадварын гэсэн 2 чиглэлээр шалгалтыг өгч “хангалттай, маш сайн” гэсэн үнэлгээ авлаа. Сургалтын туршид суралцагчид сургалтад идэвхи зүтгэлтэй, сахилга дэг журамтай оролцлоо.



ОХУ-Д РЕЛЕ ХАМГААЛАЛТЫН ИТА НАРЫГ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРУУЛАВ

ОХУ-ын Чебоксар хотод байрлах “НПП Бреслер”, Релематик үйлдвэрт 220 кВ-ын АЛТАН ГУРВАЛЖИН-ийн шинэчлэлийн ажлын хүрээнд хийгдсэн 220 кВ-ын 201, 202, 203, 204, 208, 257, 258-р АШ-ын үндсэн хамгаалалтын РХА-ийн шинэчлэлийн ажилтай холбогдуулж тус үйлдвэрүүдтэй танилцах, үндсэн хамгаалалтын реленд тавил тавих аргачлал сэдэвт сургалтанд РХАХТХ-н Нийлмэл реле хамгаалалтын инженер М.Ганзориг, УБС-н РХАХТА-ны дарга Д.Өлзийсайхан, ТБС-н РХАХТА-ны дарга Б.Эрдэнэтулга, ХБС-н РХАХТА-ны дарга Б.Энхтайван нар 2022 оны 02-р сарын 16-наас 02-р сарын 23-ны өдрүүдэд хамрагдлаа.



ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДИСПЕТЧЕР ИНЖИНЕРҮҮД ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙВ

Шуурхай зохицуулалтын хэлтэс нь 2022 оны 03 дугаар сарын 01-нээс батлагдсан хуваарийн дагуу Улаанбаатар салбарын дэд станцуудын шинэчлэгдсэн тоноглолуудтай танилцлаа. Энэ үеэр шуурхай ажиллагааны зарчмын болон дотоод хэрэгцээний схемд тулгалт хийх, “ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ НЭРШИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” байгууллагын стандартын хэрэгжилт, шинэчлэгдсэн диспетчерийн нэр хаягийн өөрчлөлтийн байдлыг газар дээр нь шалгах, сэлгэн залгалтын үлгэрчилсэн программын өөрчлөлтүүдийг газар дээр нь тоноглолтой тулгаж шалгах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Сэлгэн залгалтын үлгэрчилсэн программтай танилцаж байгаа нь



Шинэчлэгдсэн диспетчерийн нэр хаягийн өөрчлөлтийн байдлыг шалгаж байгаа нь




Хүчдэлийн трансформаторын шкафанд хоёрдогч хэлхээний шуурхай ажиллагааны бичиглэл тулгаж байгаа нь

220/110/35/10 КВ-Н ТАВАНТОЛГОЙ ДЭД СТАНЦЫН 35 КВ-Н ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛД ТЕХНИКИЙН КОМИСС АЖИЛЛАВ

Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын А/27 дугаар тушаалын дагуу “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн трассын дагуух 35 кВ-ын хүчдэлтэй хоёр хэлхээт 414.6 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төсөл”-н хүрээнд хийгдсэн 220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцын 35 кВ-н өргөтгөл, эхний 25 км урттай 35 кВ-н хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-н Шинэ өртөө дэд станц, 10/0.4 кВ-н КТПН-н барилга угсралтын ажлыг хүлээж авах техникийн комисс 2022 оны 03 дугаар сарын 16-аас 17-ны хооронд ажиллаж туршилтын хүчдэл өглөө.





ХАНГАЙН БҮСИЙН САЛБАРЫН ДАРГААР Б.ГАНТУЛГА ТОМИЛОГДЛОО

2022.02.14-ний өдөр гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу Хангайн бүсийн салбарт ажиллаа. Энэ үеэр Хангайн бүсийн салбарын даргыг томилох, ажил хүлээлцэх үйл ажиллагаа болсон юм. Тус салбарын даргаар Засварын албаны ахлах инженер Б.Гантулга томилогдлоо. Мөн Гүйцэтгэх захирал салбарын ажилтнуудтай уулзалт хийж, компанийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл хийж, үүрэг даалгавар өгсөн юм.



ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН УДИРДЛАГУУД ШИНЭЭР ТОМИЛОГДЛОО

2022.02.14-ний өдөр Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа, Төсөл хөтөлбөр хариуцсан дэд захирал Ц.Батмөнх нар Говийн бүсийн салбарт ажиллаа. Энэ үеэр Говийн бүсийн салбарын даргаар Н.Бямбадорж, ерөнхий инженерээр Д.Цэрэндамба нар томилогдож ажлаа хүлээн авлаа. Салбарын шинэ удирдлагуудад ажлыг хүлээлцүүлж баяр хүргэн амжилт хүссэний дараа уулзалт зохион байгуулж цаг үеийн мэдээ мэдээллийг танилцуулж, ажилчдын санал хүсэлтийг сонслоо.



КОМПАНИЙН СПОРТЫН ТАВАН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО

Компанийн аварга шалгаруулах “Улаанбаатар-2022” спортын таван төрөлт тэмцээн 2022.02.12-02.27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Төв удирдлага болон салбарууд өнгөрөгч оны 12 дугаар сард тэмцээнээ зохион байгуулж шилдэг баг тамирчдаа шалгаруулсан. Салбар бүрийн шилдэг тамирчид өрсөлдсөн энэ удаагийн компанийн спортын таван төрөлт тэмцээн өргөн дэлгэр болж аваргууд тодорлоо. Шатрын эмэгтэй ангилалд нэгдүгээр байрыг Говийн бүсийн салбарын ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дарга Ч.Сугиртогтох, хоёрдугаар байрыг Улаанбаатар салбарын РХАХТА-ны реле хамгаалалт автоматикийн инженер Э.Одбал, гуравдугаар байрыг төв удирдлагын Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн бэлтгэгч Ж.Цэцэгмаа тус тус эзэллээ. Шатрын эрэгтэй ангилалд Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ашиглалт хариуцсан ахлах инженер Л.Хасбаатар тэргүүлсэн бол хоёрдугаар байрт Улаанбаатар салбарын дэд станцын ээлжийн инженер Э.Төгөлдөр шалгарч, Говийн бүсийн салбарын РХАХТА-ны өндөр хүчдэлийн туршилт, хэмжилтийн монтер Д.Наваанжаргал удаалсан юм. Биллиардын тэмцээний эрэгтэй ангилалд нэгдүгээр байрт Улаанбаатар салбарын дэд станцын ээлжийн инженер Ц.Ганбат, дэд байрт Хангайн бүсийн салбарын реле хамгаалалт, автоматикийн инженер Г.Ууганбаяр, гуравдугаарт байрт Зүүн-Өмнөд бүсийн салбарын суудлын автомашины жолооч Г.Ариунболд нар тус тус шалгарчээ. Биллиардын эмэгтэй ангилалд тэргүүн байрыг төв удирдлагын ТБТХ-ийн баланс тооцооны


инженер П.Баярсүрэн, дэд байрыг Улаанбаатар салбарын дэд станцын ээлжийн монтер Д.Мөнх-Ундрах, гуравдугаар байрыг Хангайн бүсийн салбарын Засварын албаны дэд станцын засварын монтер Б.Оюундарь нар тус тус эзэлсэн юм. Ширээний теннисний төрлийн эмэгтэй ангилалд Зүүн-Өмнөд бүсийн салбарын дэд станцын ээлжийн техникч Б.Цэндмаа тэргүүлж, Төвийн бүсийн салбарын дэд станцын ээлжийн инженер Б.Дэлгэр-Эрдэнэ дэд байрт шалгарч, Улаанбаатар салбарын РХАХТХ-ийн албаны реле хамгаалалт автоматикийн инженер Э.Одбал удаалав. Ширээний теннисний эрэгтэй ангилалын нэг, хоёрдугаар байрыг Төвийн бүсийн салбарын дэд станцын ээлжийн техникч Б.Ууганбаяр, Б.Эрдэнсүх нар эзэлж, гуравдугаар байрт Улаанбаатар салбарын ээлжийн монтер Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн монтер Б.Тэмүүжин шалгарлаа. Сагсан бөмбөгийн эрэгтэй ангилалд нэгдүгээр байрт Улаанбаатар салбар, хоёрдугаар байрт Зүүн-Өмнөд бүсийн салбар, гуравдугаар байрт Төвийн бүсийн салбар шалгарсан бол эмэгтэй ангилалд тэргүүн байрыг Хангайн бүсийн салбар, дэд байрыг Улаанбаатар салбар, гутгаар байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид эзэлсэн юм. Гар бөмбөгийн эрэгтэй ангилалд нэгдүгээр байрт Зүүн-Өмнөд бүсийн салбар, хоёрдугаар байрт Улаанбаатар салбар, гуравдугаар байрт Хангайн бүсийн салбар шалгарсан амжилт үзүүлсэн бол эмэгтэй ангилалд тэргүүн байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбар, дэд байрыг төв удирдлага, гутгаар байрыг Хангайн бүсийн салбар тус тус эзэллээ.



МТХ-ИЙН ПРОГРАМИСТ ИНЖЕНЕР Б.БАЯРМАА АЗИЙН ИХ НААДАМД ОРОЛЦОХ ЭРХ АВЛАА

Азийн XIX дүгээр их наадмын шатрын төрөлд оролцох эмэгтэй тамирчдыг сонгон шалгаруулах тэмцээн" 2022 оны 02-р сарын 19-20 өдрүүдэд "Хос мастер" шатрын академийн байранд амжилттай зохион байгуулагджээ. Тэмцээнд нийт 56 шатарчин оролцож швейцарь системээр 9 өрөг тоглож өрсөлдсөн. Тэмцээний эхний 3 байр эзэлсэн
WGM А. Энхтуул (Woman Grand Master – Эмэгтэй Их Мастер)
WFM Б.Алтантуяа (Woman FIDE Master – Эмэгтэй ФИДЕ Мастер)
WIM Б. Баярмаа (Woman International Master – Эмэгтэй Олон Улсын Мастер)
нар БНХАУ-ын Ханжоу хотноо 2022 оны 09.10-25 өдрүүдэд зохион байгуулагдах Азийн спортын XIX дүгээр их наадамд Монгол улсаа төлөөлөн оролцох батламж гардан авчээ.
Азийн спортын XIX дүгээр наадамд эх орноо төлөөлөн оролцох эрх авсан эмэгтэй тамирчдад болон МТХ-ийн програмист инженер Б.Баярмаад БАЯР ХҮРГЭЖ, АМЖИЛТ ХҮСЬЕ!





КОМПАНИЙН I УЛИРЛЫН АЭД-Г ЗОХИОН БАЙГУУЛАВ

“ЦДҮС” ТӨХК-ийн 2022 оны I улиралын аваари эсэргүүцэх дасгалыг 03 дугаар сарын 25-ны өдөр “ГБС-н 220/110/35/10 кВ-н Тавантолгой д/ст 110 кВ-н II СШ-н УРОВ ажиллах үед авах арга хэмжээ” сэдвээр зохион байгуулав. Энэ үед Цанхи д/ст-д Т-2-г завсарт гаргах сэлгэн залгалтаар 110 кВ-н СаС залгаад, Т-2-н 110 кВ-н таслуурыг таслахаас өмнө 110 кВ-н Цанхи-Б АШ-н тулгуур №01-д “А” фазын шлейф тасарсан гэмтэл гарахаар өргөтгөж хийсэн. Аваари эсэргүүцэх дасгалыг ШЗХ-ийн диспетчер инженер Ч.Бат-Эрдэнэ, Х.Лхагвасүрэн, Г.Хангай, судалгаа тооцооны инженер Л.Ариунболд нар зохион байгуулж, ГБС-н 20 шуурхай ажиллагааны ажилтан оролцсон. Аваари эсэргүүцэх дасгалын дараа Тавантолгой д/ст-н шуурхай ажиллагааны хүмүүст горим ажиллагаа, сэлгэн залгалт, харьцааны заавар, шуурхай ажиллагаа, нэгдсэн сүлжээнд гарсан аваари устгах болон цахилгааны хуваарилах байгууламжид сэлгэн залгалт хийх заавруудын талаар сургалт зохион байгууллаа.



КОВИД-19 ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

- 1 Компанийн хэмжээнд вакцинжуулалтад 1-р тунд 1258 ажилтан, 2-р тунд 1252 ажилтан, 3-р тунд 1071 ажилтан, 4-р тунд 222 ажилтан хамрагдаад байна. Үүнээс өөрийн хүсэлтээр 1, эмнэлгийн заалтаар 9 ажилтан хамрагдаагүй байна
- 2 Сүүлийн 14 хоногт компанийн хэмжээнд 2 ажилтан шинээр болон давтан халдвар авсан байна
- 3 Батлагдсан тохиолдол 733, эдгэрсэн 732, эмчлэгдэж байгаа болон гэрээр тусгаарлалтад 1 ажилтан байна.
- 4 Нийт 1 ажилтан эмнэлэгт эмчлэгдэж байна.

Үзүүлэлт /2022.03.21/									
Д/д	Нэр	Нийт ажилтан	1-р тунд	Хувь	2-р тунд	Хувь	3-р тунд	Хувь	4-р тунд
1	Төв удирдлага	155	155	100.00%	154	99.35%	128	82.58%	22
2	УБС	395	392	96.08%	389	98.48%	369	93.42%	144
3	ЗӨБС	206	205	99.50%	205	99.51%	175	84.95%	11
4	ТБС	216	215	99.53%	214	99.07%	188	87.04%	40
5	ХБС	184	185	100.54%	186	101.09%	119	64.67%	5
6	ГБС	108	106	98.15%	104	98.11%	92	88.46%	0
Дундаж		1264	1258	98.97%	1252	99.27%	1071	83.52%	222

ОН ГАРСНААС ХОЙШ 191 АЖИЛТАН ШИНЭЭР БОЛОН ДАВТАН
ХАЛДВАР АВСАН БАЙНА

ТБС-ын ХАБЭА-н инженер, МУ-ын зөвлөх инженер Дэлгэрийн Цэцэг 2021 онд гавьяаныхаа амралтад гарсан билээ. Амьдралынхаа салшгүй нэгэн хэсэг болсон цахилгаан дамжуулах их үйлсэд хүчин зүтгэж ирсэн гэрэлт өдрүүдээ дурсаж “Би азтай хүн” дурсамж бичиж ирүүлснийг уламжилъя.

Би азтай хүн

Дурсамж

Би 1995 оны 1-р сарын 01-нээс 2009 оны 7-р сарын 01-ний өдрийг хүртэл 220/110/35 кВ-ын Дархан дэд станцад диспетчер инженерээр 14 жил ажиллалаа. Энэ хугацаанд Монгол улс, ОХУ-ыг холбосон зангилаа дэд станцад ДСЦШСГ-ын анхдагчид, Дархан дэд станцын анхны диспетчер инженер П.Рэнцэндорж, П.Давгадорж, Ш.Тангад нартай мөр зэрэгцэн ажиллаж байснаараа бахархдаг.

ОХУ-д мэргэжил эзэмшсэн, мэдлэгтэй, туршлагатай инженер П.Рэнцэндоржийг дагалдан суралцаж 1 сарын дотор шалгалтаа амжилттай өгөөд ээлжинд гарч эхэлсэн.

Диспетчер инженерээр ажиллаж эхэлсэн үеийн дурсамжаас хуваалцъя. 1995 оны 7-р сарын 11-ний өдөр 16 цаг өнгөрөөд 257-р агаарын шугам хамгаалалтаар тасарч Монгол улсын эрчим хүчний систем, ОХУ-ын эрчим хүчний системээс тусдаа гарлаа. Надад анх таарч байгаа томоохон тасралт. Системийн диспетчерээс синхрон хийж залгах шийдвэр аваад параметрээ хянаад “Буруу үйлдэл хийчих вий” гэж эмээж зогсол Рэнцэндорж инженер надаас ээлж авахаар ороод ирлээ. Би ч тайвшираад явчихлаа. Рэнцэндорж инженер маань синхроны колонкын дэргэд зогсоод синхрон хийх боломж таарангуут “За залга” гээд надаар залгууллаа. Амжилттай ч боллоо. Монгол улсын эрчим хүчний системийг ОХУ-ын эрчим хүчний системтэй анх холбож байсан багштайгаа анхныхаа синхрон холболт хийж систем холбож байлаа. Би азтай хүн. Энэ бол ховорхон тохиолдол.

Тэр цагаас хойш олон ч удаа синхрон хийж, олон ч удаа томоохон аваарийн тасралттай таарч байлаа. Ялангуяа миний ээлжинд систем тусдаа гарах, 208-р шугамын нэг фаз татгалзаж УРОВ ажиллаж секцээрээ “0” суух гэх мэт томоохон тасралтууд их гардаг байв. Энэ олон удаагийн тасралтууд таарснаар туршлагажиж, хир баргийн юманд сандарч тэвдэхээ больсон. Тэгээд ч аваарийн тасралтаар буруу үйлдэл хийж алдаа гаргаж байсангүй. Үүнд дараах зүйлүүд нөлөөлсөн гэж боддог.

Орой ээлжинд гарахдаа зав гарангуут л өөрөө өөртөө “Аваари эсэргүүцэх дасгал” хийнэ шүү дээ. Аваарийн процессын үед реле хамгаалалт яаж ажиллах, хаана блинкер унах, тоноглолын ажиллагааг яаж шалгах, гэмтэлийг яаж тодорхойлох гэх мэтээр өөрийгөө шалганаа. Мэдэхгүй зүйл гараад ирнэ. РХА-ын инженер Б.Батболдоос их зүйл асууж мэдэж авсан даа. Өрөөндөө ороод “Наашаа суу” гээд л ярьж өгнө дөө. Ярьсан зүйлийг нь тэмдэглэж аваад дараа нь сийрүүлж бичиж сургалтын материалтай болдог байлаа. Нэг асуусан зүйлээ дахиад асуухаар дургуйцдэг инженер байлаа. Батболд инженер маань их ч зүйлийг зааж сургасан даа. Батболд инженер их нямбай. Томоохон сэлгэн залгалт хийсний дараа накладка, тэжээлийн блокын байрлалыг заавал шалгана. Дутуу зүйл байвал тухайн диспетчерийг дуудаад ширүүхэн дуугараад алдаагийн хэлж өгнө. Түүний ачаар тухайн үед хамгаалалт дутуу гаргаж тасралт гарсан алдаа гарч байгаагүй. Тоноглолын талаар О.Чимэд-Ёндон мастераас асууна. Бүх зүйлийг нарийн хэлж өгнө. Ингэж туршлагатай ахмадуудаасаа суралцаж байлаа.




Монгол улсын зөвлөх инженер
Дэлгэрийн Цэцэг

дугаар агаарын шугамын салгуур, шинний салгуур таслах шийдвэр аваад гараад шугамын салгуураа тасалтал шин дагаад хөх гал маналзаад явчихлаа. Гүйж орж ирээд хэмжүүрийн заалтуудыг шалгахад 202 дугаар агаарын шугамаар хүчдэл ирчихсэн ачаалалтай байлаа. ДҮТ-ийн диспетчер Ганболдод 202 дугаар шугамаар 2-р секцэнд хүчдэл ирчихсэн байна, 208 дугаар шугамын салгуур таслахад шин дагаад хөх гал маналзсан гэж хэлэхэд “Үгүй байлгүй дээ” гээд гайхснаа “Эргээд ярь” гээд утсаа тасаллаа. Эргэж орж ирснээ Эрдэнэт дэд станц дээр залгачихсан байна, таслуулчихлаа сэлгэн залгалтаа үргэлжлүүлэн хий гэсэн шийдвэр өглөө. Энэ хооронд монтёр Х.Нямбаяр болсон процессоо удирдлагуудад танилцуулаад бүгдийн дуудчихсан байсан. Сэлгэн залгалт хийж дуусч байтал салбарын дарга С.Ганхуяг, ерөнхий инженер С.Болд, ашиглалт засварын албаны дарга Ш.Мөнхөө, ахлах диспетчер М.Энхсод нар ирлээ. Тэд тойрч суугаад болсон процессыг яриулж эхэлтэл системийн диспетчер юм асуухаар дуудна. Асуусан зүйлийн хариулчихаад дахиад ярьж эхэлтэл дахиад л дуудна. Тэр үед системийн диспетчер монтёроос мэдээлэл авдаггүй заавал диспетчертэй ярьдаг байсан. Салбарын удирдлагууд “Ээлжээ өгөөд журналын хуулбараа бичээд сүлжээн дээр хүрээд ир тэгээд хуралдана” гээд явлаа. Тэр өдрийн хурлаар салбарын диспетчер асар их ачаалалтай байдаг юм байна. Ээлжийн монтёрын оронд техникч байх шаардлагатай гэсэн шийдвэр гарсан. Ингэж бодит байдлыг газар дээр нь ойлгуулсны ачаар Дархан дэд станцад бүтцийн өөрчлөлтийг нэг алхамаар дээшлүүлж чадсан юм. Энэ тасралтын дараа 7-р сарын 01-ний өдрөөс би Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерээр, ээлжийн монтёр Х.Нямбаяр хангамжийн мэргэжилтнээр дэвшин томилогдож байлаа.

Улсад нийт 33 жил ажиллах хугацаандаа Монгол улсын Зөвлөх инженер, Техникийн ухааны магистр болсоногоо энэ сайхан хамт олон болон байгууллагын маань ач тус гэж баярлаж явдаг.

Дархан дэд станц байгуулагдаж, Монгол улсын эрчим хүчний систем, ОХУ-ын эрчим хүчний системтэй холбогдсоны 45 жилийн ойн баярын мэндийг энэ дэд станцад ажиллаж байсан ахмадууд болон мэргэжил нэгт нөхөддөө хүргэж, ажил үйлс нь мандан бадарч явахын өлзийтэй ерөөлийг дэвшүүлъя.



МОНГОЛ БИЧГИЙН БУЛАН

ӨМНӨХ ДУГААРТ: ДЭВСГЭР ҮСЭГ, УРТ ЭГШИГ, НЭР ҮГИЙН ХУВИЛАЛЫН ДҮРТИЙГ НИЙТЭЛСЭН. ЭНЭ УДААГИЙН ДУГААРААР МОНГОЛ БИЧГИЙН НЭРИЙН ТИЙН ЯЛГАЛ, ХАМААТУУЛАХ НӨХЦӨЛ, ХОЛБОХ ЭГШГИЙН ДҮРЭМ, ЭС ХУВИЛАГЧ ҮСГИЙН ДҮРЭМ, ҮЙЛ ҮГИЙН ХУВИЛАЛЫН ДҮРМИЙГ ХҮРГЭЖ БАЙНА.

Цуврал-3

Монгол улсад идэвхитэй ажиллаж байгаа 160 гаруй мянган төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа 2020 оны 10 сараас эхэлсэн билээ. Энэхүү судалгааг Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Үндэсний статистикийн хороо хамтран зохион байгуулж байгаа юм. Тэгвэл манай сонин компанийхаа ажилтан, албан хаагчидад үндэсний бичгийн мэдлэг олгох зорилгоор монгол бичгийн хичээлийг цувралаар хүргэж байна.

НЭРИЙН ТИЙН ЯЛГАЛ	НӨХЦӨЛ		Нэр үгийн төгсгөл				Жишээ
	МОНГОЛ БИЧИГТ	МОНГОЛ ХЭЛЭНД	ЭГШИГ	Н	М, Л, НГ	Б, Г, Р, С, Д	
Нэрлэх	-	-	-	-	-	-	ᠨᠡᠷᠯᠡᠭ
Харьяалах	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-ы, -ын, -ий, -ийн, -н	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠬᠠᠷᠢᠶ᠋ᠠᠯᠠᠭ
Өгөх орших	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-д, -т	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠣᠭᠦᠬᠡ
Заах	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-ыг, -ийг, -г	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠵᠠᠭ
Гарах	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-аас ⁴	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠭᠠᠷᠠᠬᠤ
Үйлдэх	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-аар ⁴	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠤᠢᠯᠠᠳᠤᠬᠤ
Хамтрах	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-тай ³ (-лугаа ²)	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠬᠠᠮᠲᠤᠷᠠᠬᠤ
Чиглэх	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-руу ² -луу ²	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠴᠢᠭᠯᠡᠬᠤ

Хамаатуулах нөхцөл

Эзэнд хамаатуулах нөхцөл		Биед хамаатуулах нөхцөл		
Эгшиг	Гийгүүлэгч	I бие	II бие	III бие
ᠠ	ᠠ	ᠠ	ᠡ	ᠢ
ᠡ	ᠡ	ᠡ	ᠢ	ᠣ
ᠢ	ᠢ	ᠢ	ᠣ	ᠤ
ᠣ	ᠣ	ᠣ	ᠤ	ᠥ
ᠤ	ᠤ	ᠤ	ᠥ	ᠦ
ᠥ	ᠥ	ᠥ	ᠦ	ᠨ
ᠦ	ᠦ	ᠦ	ᠨ	ᠭ
-аа, -ээ, -оо, -өө		минь маань	чинь тань	нь

Тийн ялгалтай хамаатуулах нөхцөл

	Харьяалах	Өгөх орших	Заах	Гарах	Үйлдэх	Хамтрах
ᠠ	-ынхаа ² -ийнхээ ²	-даа ⁴ -таа ⁴	-ыгаа ² -ийгээ ²	-аасаа ⁴	-аараа ⁴	-тайгаа ⁴
ᠡ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ
ᠢ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ
ᠣ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ
ᠤ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ
ᠥ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ
ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ

ХОЛБОХ ЭГШГИЙН ДҮРЭМ

Монгол бичигт үйл үг эгшиг болон хувилагч үсгээр төгсдөг бөгөөд дагавар, нөхцөл нь гийгүүлэгчээр эхэлдэг тул эгшгээр төгссөн үйл үгэнд бүх нөхцөлийг шууд залган бичдэг.

Харин хувилагч үсэг (н, б, д, р, с, л) -ээр төгссөн үйл үгэнд хувилгагч үсэг (й, г, н, м, л, р) -ээр эхэлсэн нөхцөл, (-си, -схий) дагавар залгахад дунд нь эгшиг у, ү нэмж бичдэг дүрмийг холбох эгшгийн дүрэм гэнэ.

Хувилагч үсэг	Хувилгагч үсэг
н, б, д, р, с, л + й, г, н, м, л, р = Ч	
ᠨ, ᠪ, ᠳ, ᠷ, ᠰ, ᠯ + ᠶ, ᠭ, ᠨ, ᠮ, ᠯ, ᠷ = Ч	

ЭС ХУВИЛГАГЧ ҮГСИЙН ДҮРЭМ

Н, б, д, р, с, л -ээр төгссөн үгэнд ж, ч, б, с, д, х, т-ээр эхэлсэн нөхцөл залгахад холбох эгшиг нэмэлгүй шууд залгадаг дүрмийг эс хувилгагч үгсийн дүрэм гэнэ.

НаБДаРСал + ЖиЧ БуСаД ХоТ = шууд залгана.

Эс хувилгагч үгсийн дүрэм
ᠨ, ᠪ, ᠳ, ᠷ, ᠰ, ᠯ + ᠶ, ᠭ, ᠨ, ᠮ, ᠯ, ᠷ = Ч
ᠨ, ᠪ, ᠳ, ᠷ, ᠰ, ᠯ + ᠶ, ᠭ, ᠨ, ᠮ, ᠯ, ᠷ = Ч

ҮЙЛ ҮГИЙН ХУВИЛАЛ

Үйл үгийн нөхцөлийг үгэнд залгахдаа эр эмийг харгалзах ба эгшиг зохицох ёсыг баримтална.

Үйл үгийн нөхцөлийг зөв бичихийн тулд доорхи гурван дүрмийг мэдэх нь чухал. Үүнд:

1. Холбох эгшгийн дүрэм
2. Эс хувилгагч үгсийн дүрэм
3. Холбох эгшгийн онцлох дүрэм

Үйлийн хэвийн дагавар

Өөрөө үйлдэх хэв	Бусдаар үйлдүүлэх хэв	Бусдын эрхэнд үйлдэгдэх хэв	Бусдтай хамтран үйлдэлцэх хэв	Бусдтай харилцан үйлдэлдэх хэв
ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	-уул ² -аа ⁴ -га ⁴ -лга ⁴	-гд -д -т	-лц	-лд
ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ	ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ